

**ХӨТӨЛБӨРИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2025 оны 12 дугаар сарын 25

№03

Улаанбаатар хот

Хөтөлбөрийн ерөнхий хорооны хурал 2025 оны 12 дугаар сарын 25-ны өдөр 10:00 цагаас 76,2 хувийн ирцтэй эхэлж, ХЕХ-ны дарга Н.Эрдэнэхүү удирдан явуулав.

Хуралд:

Хөтөлбөрийн ерөнхий хорооны дарга

1. Н.Эрдэнэхүү Сургалт, оюутны асуудал эрхэлсэн проректор

Нарийн бичгийн дарга

2. М.Эрдэнэтуяа Сургалтын бодлого, зохицуулалтын албаны дарга

Гишүүд

3. И.Цэрэн-Онолт АТС-ийн захирлын үүрэг гүйцэтгэгч
4. Б.Майзул ХХҮДС-ийн биотехнологи, шим судлалын тэнхимийн профессор
5. Д.Ариунболор НБХ-ийн профессор
6. Ц.Балжинням ХШУС-ийн сургалт, чанарын албаны дарга
7. П.Ууганбаяр МХТС-ийн сургалт, чанарын албаны дарга
8. Ш.Цоож МИТС-ийн механик инженерчлэлийн тэнхимийн дэд профессор
9. Я.Наранцэцэг АТС-ийн профессор
10. И.Базаррагчаа МИТС-ийн тээвэр, логистикийн тэнхимийн эрхлэгч
11. Ц.Энхбаатар ГХС-ийн захирал
12. Ч.Алдармаа ХШУС-ийн физикийн тэнхимийн профессор (ӨмТДС-ийн төлөөлөл, зөвшилцсөнөөр)
13. Д.Үлэмж ЭХИС-ийн эрдэмтэн нарийн бичгийн дарга
14. С.Туяа НХС-ийн сургалт, чанарын албаны дарга
15. Г.Өлзийсайхан ГУУС-ийн сургалт, чанарын албаны дарга
16. Г.Ариунтөгс Сургалтын бодлого, зохицуулалтын албаны ахлах мэргэжилтэн

нар оролцов.

Хэлэлцэх асуудлууд:

1. “061202. Кибер аюулгүй байдал” докторын хөтөлбөр нээх тухай (МХТС)
- МХТС-ийн ХДХ-ны ахлагч П.Ууганбаяр
2. “068801. Компьютер-хэл шинжлэл” магистрын хөтөлбөр нээх тухай (ГХС)
- ГХС-ийн ХДХ-ны ахлагч А.Болормаа
3. ГХС-ийн “Гадаад хэлний орчуулга” (хятад, англи хэл) хөтөлбөрөөр БНХАУ-ын Шаньдун ШУТИС-тай оюутан солилцооны хөтөлбөр хэрэгжүүлэх
- ГХС-ийн ХДХ-ны ахлагч А.Болормаа
4. “Дээд боловсролын сургалтын байгууллагад мөрдөх мэргэжлийн чиглэл, индекс”-ийн жагсаалтад “Инженерчлэл ба хиймэл оюун” ахисан түвшний мэргэжлийн чиглэлийг (индекс) шинээр нэмүүлэх (АТС)
- АТС-ийн захирал И.Цэрэн-Онолт
5. “Дээд боловсролын сургалтын байгууллагад мөрдөх мэргэжлийн чиглэл, индекс”-ийн жагсаалтын “078807 Үйлдвэрлэлийн инженерчлэл” мэргэжлийн чиглэлд магистр, докторын түвшин нэмүүлэх (АТС)
- АТС-ийн захирал И.Цэрэн-Онолт
6. Бусад асуудал

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

1. МХТС-д 061202. Кибер аюулгүй байдал докторын хөтөлбөр нээх тухай асуудлыг томилогдсон шинжээчийн зөвлөмжийн дагуу зарим бүлэг хэсэгт сайжруулалтыг хийн урьдчилсан магадлан итгэмжлэл хийлгэх БМИҮЗ-д хүсэлт хүргүүлэхийг гишүүдийн 100 хувийн саналаар дэмжлээ.
2. ГХС-д “068801. Компьютер-хэл шинжлэл” магистрын хөтөлбөр нээх тухай асуудлыг ГХС, МХТС-ийн хөтөлбөрийн дэд хороодын хамтарсан хурлаар хэлэлцүүлж, томилогдсон шинжээч, хөтөлбөрийн ерөнхий хорооны гишүүдийн зөвлөмжийн дагуу сайжруулалт хийн, докторын түвшин нэмэх саналын хамт хөтөлбөрийн ерөнхий хорооны хуралд дахин хэлэлцүүлэхээр буцаалаа.
3. ГХС-ийн “Гадаад хэлний орчуулга” (хятад, англи хэл) хөтөлбөрөөр БНХАУ-ын Шаньдун ШУТИС-тай оюутан солилцооны хөтөлбөр хэрэгжүүлэх асуудлыг хичээлийн дүйцүүлэлтийг хөтөлбөрийн ерөнхий хорооны гишүүдэд танилцуулан санал зөвлөмжийг авч, цаашид тухайн оюутан солилцооны хөтөлбөрийг хэрэгжүүлэхийг гишүүдийн 94 хувийн саналаар дэмжлээ.
4. АТС-аас гаргаж буй “Инженерчлэл ба хиймэл оюун” ахисан түвшний мэргэжлийн чиглэлийг (индекс) шинээр нэмүүлэх асуудлыг 0788 салбар дундын чиглэлд “Дээд боловсролын сургалтын байгууллагад мөрдөх мэргэжлийн чиглэл, индекс”-ийн жагсаалтад нэмүүлэх саналыг гишүүдийн 100 хувийн саналаар дэмжлээ.
5. АТС-аас гаргаж буй “078807 Үйлдвэрлэлийн инженерчлэл” мэргэжлийн чиглэлд магистр, докторын түвшин нэмүүлэх, докторын хөтөлбөрийн боловсролын зэргийг инженерийн доктор (Doctor of Engineering/D.Eng.) гэж олгох саналыг гишүүдийн 100 хувийн саналаар дэмжлээ. 4, 5 дугаар асуудлын саналыг Боловсролын яаманд хүргүүлэхийг сургалт эрхэлсэн захиргааны нэгжид үүрэг болгов.
6. Сургалтын хөтөлбөрийн боловсролын зэргийг тодорхойлох тухай захиргааны саналыг хөтөлбөрийн ерөнхий хорооны гишүүд хөтөлбөрийн дэд хороондоо хэлэлцүүлж, саналыг цахимаар захиргааны нэгжид хүргүүлэн хөтөлбөрийн ерөнхий хорооны хурлаар дахин хэлэлцэхээр тогтлоо.